



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 06

Сангийндалай

Сумын 2024 оны Газар зохион байгуулалтын
төлөвлөгөөний тодотголыг
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дах хэсгийг үндэслэн, Сумын " 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотгол"-ын төслийг хэлэлцээд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын " 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-нд орсон нэмэлт тодотголыг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Газрын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу газрыг өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулах ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга (Б.Лхагвамандал)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хороодод үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ЧУЛУУН

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын
16-ны өдрийн 06 дугаар тогтоолын хавсралт



2024-12-048-8262 / Эрдэнэдалай сумын 2024 оны ГЗБТөлөвлөгөөний тодотгол / Дундговь / Эрдэнэдалай

20616001: Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгох газар

№	Сум/Дүүрэг	Баг/Хороо	Төлөвлөлтийн нэгж талбар	Газрын байршил нэгж талбар бүрээр	Газрын нэр	Газрын зориулалт	Талбайн хэмжээ [m2]	Улирал I	Улирал II	Улирал III	Улирал IV
1	Эрдэнэдалай	7-р баг, Төв	4040812	X=495928.08 Y=5093986.92 X=495940.97 Y=5093949.05 X=496189.47 Y=5094025.52 X=496176.58 Y=5094063.39 X=495928.08 Y=5093986.92	7-р баг Их ус урд талд	2317: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэл	10396	+	+	+	+

